




# НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021/02

ᠨᠠᠯᠠᠶᠢᠬᠡ ᠳᠦᠦᠷᠭᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠤᠰ



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2017-2021 ОН	2
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	3
 ИРГЭНИЙ БҮРТГЭЛ	4-5
 НИЙГМИЙН ДААТГАЛ	6-7
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
 ЭРҮҮЛ МЭНД	7-9
 СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР	9
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	9-10
 ТӨСӨВ	10
 ГЭМТ ХЭРЭГ	11
 ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ	12
 АЖ ҮЙЛДВЭР	13
 ХАРИЛЦАА ХОЛБОО	14
 АЮУЛГҮЙ БАЙДАЛ	14-15
 ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ	16



## ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021
Суурин хүн ам, жилийн эцэст	тоо	36 911	37 608	37 715	38690	-
Шинээр төрсөн хүүхэд	тоо	106	130	143	144	112
Ажилгүйчүүд, сарын эцэст	тоо	328	212	134	259	91
Үүнээс: эмэгтэй	тоо	169	94	70	128	31
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	83	33	80	83	72
Бүртгэсэн гэмт хэрэг	тоо	55	96	75	54	42
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	3 144.1	3 327.2	3 774.2	2 050.6	6 166.4
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	2 567.6	2 794.1	3 422.0	2 680.3	5 577.5

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс



## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Дүүргийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй, ажилгүй иргэдийн тоо 2021 оны эхний 2 сард 91 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 168 хүнээр (65.8%) буурсан ба 34.0 хувь нь эмэгтэйчүүд эзлэж байна.

Бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 34.0 хувь нь 15-24 насны залуучууд, 32.9 хувь нь 25-34 насныхан, 15.4 хувь нь 35-44 насныхан, 13.2 хувь нь 45-54 насны, 2.2 хувь нь 55-59 насны, 60 дээш насныхан 2.2 хувийг эзэлж байна. Үүнээс: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2.2% байна.

Хүснэгт 2. Дүүргийн ажилгүйчүүд, насны бүлэг, хүйсээр, жил бүрийн II сард

Үзүүлэлт	2018 II		2019 II		2020 II		2021 II	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажилгүйчүүд	212	94	134	70	259	128	91	31
Насны бүлгээр:								
15-24	32	14	17	6	103	50	31	8
25-34	88	40	47	27	67	37	30	13
35-44	50	23	39	21	56	23	14	5
45-54	30	14	26	12	23	14	12	4
55-59	7	3	5	4	8	2	2	1
60 +	5	-	-	-	2	-	2	-
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	2	2	5	3	3	2	2	2

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо				Дүнд эзлэх хувь			
	2018 II	2019 II	2020 II	2021 II	2018 II	2019 II	2020 II	2021 II
Ажилгүйчүүд, бүгд	212	134	259	91	100.0	100.0	100.0	100
Үүнээс:								
Магистр, доктор	1	2	1	1	0.5	1.5	0.4	1.1
Дипломын болон бакалавр	36	27	44	13	17.0	20.1	17.0	14.3
Тусгай мэргэжлийн дунд	18	6	6	5	8.5	4.5	2.3	5.5
Техникийн болон мэргэжлийн	30	20	18	6	14.1	15.0	6.9	6.6
Бүрэн дунд	107	68	174	58	50.5	50.7	67.2	63.7
Суурь	12	8	10	6	5.6	6.0	3.9	6.6
Бага боловсрол	4	3	1	1	1.9	2.2	0.4	1.1
Боловсролгүй	4	-	5	1	1.9	-	1.9	1.1

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс



## ИРГЭНИЙ БҮРТГЭЛ


2021 оны эхний 2 сард шинээр төрсөн 112 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн авч, нас барсан 34 хүнийг бүртгэлээс хасаж, 46 гэрлэлт, 4 хосын гэр бүл цуцлалтыг тус тус бүртгэсэн байна.

Шинээр мэндэлсэн хүүхдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32 хүүхдээр (22.2%) , нас баралт өмнөх оны мөн үеэс 12 (18.7%) тус тус буурсан байна. Нийт мэндэлсэн хүүхдийн 53.6 хувь нь хүү, 46.4 хувь нь охин байна. Нийт нас баралтад 67.6 хувь нь эрэгтэй, 32.4 хувь нь эмэгтэй хүн эзлэж байна.

Хүснэгт 4. Төрөлт, нас баралтын бүртгэл, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Төрсөн хүүхэд, бүгд	106	130	143	144	112
Үүнээс:					
Эрэгтэй	55	69	75	80	60
Эмэгтэй	51	61	68	64	52
Нас баралт, бүгд	41	32	41	34	34
Үүнээс:					
Эрэгтэй	26	20	29	22	23
Эмэгтэй	15	12	12	12	11

Зураг 1. Хүн амын ердийн цэвэр өсөлт



Хүснэгт 5. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүн, насны бүлгээр, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2019 I-II			2020 I-II			2021 I-II		
	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд	эрэгтэй	эмэгтэй
Нийт	50	25	25	66	33	33	92	46	46
18-19	-	-	-	1	-	1	1	1	-
20-24	10	4	6	5	2	3	23	8	15
25-29	15	7	8	15	6	9	36	19	17
30-34	10	5	5	27	15	12	23	13	10
35-39	5	4	1	9	5	4	7	4	3
40-44	3	1	2	1	1	-	2	1	1
45-49	2	1	1	7	4	3	-	-	-
50 +	5	3	2	1	-	1	-	-	-

2021 оны эхний 2 сард гэрлэлтээ баталгаажуулсан 46 хос байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 (39.4%) өссөн. Хосуудыг насны бүлгээр нь авч үзвэл 1.0 % нь 18-19 насны, 25.0% нь 20-24 насны, 39.2% нь 25-29 насны, 25.0% нь 30-34 насны, 7.6% нь 35-39 насны, 2.2% нь 40-44 насныхан байна.

Хүснэгт 6. Гэр бүл цуцлалт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт		2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Гэр бүл цуцлалт, бүгд		11	10	12	7	4
Гэр бүл байсан хугацаагаар (жилээр)	1 хүртэл	1	-	1	-	-
	1-3	1	-	-	-	-
	4-6	2	1	2	-	1
	7-9	3	3	3	-	1
	10-14	3	4	4	6	2
	15-19	1	-	1	1	-
	20 ба түүнээс дээш	-	2	1	-	-

2021 оны эхний 2 сард нийт 4 хос гэр бүлээ цуцлуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 (42.8%) буурсан байна. Гэр бүл байсан хугацаагаар 25.0% нь 4-6 жил, 25.0% нь 7-9 жил, 50.0% нь 10-14 жил хангилсан хосууд байна.

Дүүрэгт 2021 оны эхний 2 сард үрчлэгдсэн 3 /эрэгтэй 2, эмэгтэй 1/ хүүхэд байна.

Хүснэгт 7. Үрчлэлтийн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Үрчлэгдсэн хүүхэд, бүгд	3	-	1	3	3
Үүнээс: насны бүлгээр					
3 хүртэл	3	-	1	1	3
3-6	-	-	-	1	-
10 ба түүнээс дээш	-	-	-	1	-

Эх үүсвэр: Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс




## НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны эхний 2 сард нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1427.5 сая төгрөгт хүрч, нийгмийн даатгалын санд төвлөрчээ. Нийгмийн даатгалын сангаас эхний 2 сард 11491 даатгуулагч иргэнд 5052.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна.

Хүснэгт 8. Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт, эхний эхний II сард

Үзүүлэлт	2020 I-II		2021 I-II		Даатгуулагчдын тоо	
	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Даатгуулагчдын тоо	Олгосон дүн (сая төгрөг)	Тоо	Өсөлт, бууралт хувь
Нийт орлого	-	3 200.0	-	1 427.5	-	-
Нийт зардал	12 620	4 597.0	11 491	5 052.3	-1129↓	-8.9↓
Тэтгэврийн даатгалын сан	11 527	3 943.3	10 451	4 344.3	-976↓	-17.1↓
Өндөр насны тэтгэвэр	6 902	2 744.3	7 273	3 023.8	371↑	5.4↑
Тахир дутуугийн тэтгэвэр	3 130	469.8	1 633	526.7	-1497↓	-47.8↓
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	589	176.2	612	189.4	23↑	3.9↑
Цэргийн тэтгэвэр	906	552.8	933	604.4	27↑	2.9↑
ҮОМШӨ-ний даатгалын сан	843	440.1	818	434.3	-25↓	-2.9↓
Тахир дутуугийн тэтгэвэр	795	120.0	772	414.8	-23↓	-2.9↓
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	48	20.1	46	19.5	-2↓	-4.1↓
Тэтгэмжийн даатгалын сан	215	147.3	171	135.2	-44↓	-20.4↓
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	107	10.1	71	10.9	-36↓	-33.6↓
Жирэмсний амралт	72	97.2	77	101.3	5↑	6.9↑
Оршуулга	36	36.0	23	23.0	-13↓	36.1↑
Ажилгүйдлийн даатгалын сан	35	66.3	51	138.5	16↑	45.7↑
Ажилгүйдлийн тэтгэмж	35	66.3	51	138.5	16↑	45.7↑

Зураг 2. Даатгалын сангийн зарлага



Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 2021 оны эхний 2 сард 10451, олгосон тэтгэврийн хэмжээ 4344.3 сая төгрөгт хүрчээ. Олгосон нийт тэтгэврийн 69.6 хувийг өндөр насны 12.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.4 хувийг тэжээгчээ алдсан, 13.9 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



## НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 2 сард давхардсан тоогоор нийт 8935 хүнд халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ үзүүлж, халамжийн зардлын хэмжээ өссөн дүнгээр 919.4 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 9. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн үзүүлэлт

	2020		2021		<u>2021%</u> 2020	
	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Хүний тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)	Мөнгөн дүн (сая төгрөг)	Өсөлт, бууралт хувь
	II	I-II	II	I-II	I-II	I-II
Халамжийн орлого, бүгд	-	1 258.4	-	919.4	-	-339.0
Зарцуулалт, бүгд	15 204	1 283.2	8 935	879.9	-403.3	-31.4
Халамжийн тэтгэвэр	793	289.9	817	478.9	189.0	65.2
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	370	54.1	635	121.2	67.1	124.0
Жирэмсэн эхийн тэтгэмж	338	10.9	-	*	-10.9	-
Ахмад настны хөнгөлөлт	291	51.4	130	19.4	-32.0	-62.3
Халамжийн тэтгэмж	601	99.8	-	*	-99.8	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд	177	32.1	57	8.6	-23.5	-73.2
Алдарт эхийн одонгийн тусламж	2 594	339.8	-	*	-339.8	-
Алдар цолтой ахмад настнуудад олгосон	13	5.9	-	*	-5.9	-
Хүнс тэжээл хөтөлбөрийн зардал	6 612	156.4	6 847	161.8	5.4	3.5
Насны хишгийн зардал	1 781	141.6	-	*	-141.6	-
Цалинтай ээж хөтөлбөр	1 631	79.1	-	*	-79.1	-
Онцгой тохиолдлын	3	3.6	2	2.4	-1.2	-33.3
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж			447	87.6	87.6	-
Бусад зардал		18.6	-	*	-18.6	-

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс

\*2021 оноос халамжийн үйлчилгээний зарим санхүүжилт улсын төсвөөс шууд иргэдэд олгогддог болсон.



## ЭРҮҮЛ МЭНД

2021 оны эхний 2 сард төрсөн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 6 (4.0%), нас баралт 4 (8.5%) тус тус буурсан байна.



Хүснэгт 10. Төрөлт , жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Амаржсан эхийн тоо, бүгд	108	138	142	149	143
Амьд төрсөн хүүхэд	112	141	142	150	143
Амьгүй төрсөн	-	-	-	-	1
Эхийн эндэгдэл	-	-	-	1	-
Нас баралт	46	38	49	47	43
Үүнээс: нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	3	1	3	1	3
Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт	1	5	4	1	4
Гэрийн нөхцөлд гарсан нас баралт	36	30	38	35	30
Улаанбаатар хотод бүртгэгдсэн нас баралт <sup>1</sup>	6	3	7	11	9

2021 оны эхний 2 сард бүртгэгдсэн нийт нас баралтын 69.7 хувийг гэрийн орчин нөхцөлд гарсан нас баралт, 20.9 хувийг Улаанбаатар хотод хэвтэн эмчлүүлж байсан нас баралт, 9.4 хувийг Эмнэлгийн нөхцөлд гарсан нас баралт эзэлж байна.

Хүснэгт 11. Дүүргийн хэмжээнд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Нийт халдварт өвчин	83	73	80	83	72
Хурц халдварт өвчин:	7	33	17	16	20
Хепатит В вирус	-	-	-	1	-
Хепатит С вирус	-	-	1	-	1
Менинжет	-	1	-	-	-
Салхин цэцэг	4	27	9	12	3
Паротит	-	-	1	-	-
Бруцеллез	-	-	1	-	-
Ёлом	-	-	-	1	-
Дизентери	-	3	2	-	-
Гар, хөл, амны өвчин	1	-	3	1	-
Улаан эсэргэнэ	2	1	-	1	-
Эритема	-	1	-	-	-
Ковид	-	-	-	-	16
Сүрьеэ	10	11	14	3	8
Арьс өнгөний өвчин	66	29	49	64	44
Тэмбүү	11	12	10	12	18
Үүнээс: төрөлхийн	-	-	-	-	-
Заг хүйтэн	10	9	13	26	14
Бэлгийн замын мөөгөнцөр	29	2	12	17	6
Мөөгөнцөр	2	-	-	-	-
Трихомониаз	14	6	14	9	6

Эрүүл мэндийн үзүүлэлтээр дүүргийн хэмжээнд халдварт өвчнөөр 20 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 (25.0%), сүрьеэгээр 8 хүн өвчилсөн нь 5 (1.6 дахин) тус тус өсч, арьс өнгөний өвчлөл 44 гарсан нь 20 (31.2%) буурсан байна.

Нийт халдварт өвчний гаралт 72 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 (13.2%) буурсан байна.


<sup>1</sup> Дүүргийн харьяат иргэдээс Улаанбаатар хотын эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаад гарсан нас баралт

Хүснэгт 12. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Урьдчилан сэргийлэх тарилга	1 043	961	953	1 114	1 116
Амбулаторын үзлэг	28 928	34 848	28 634	28 599	24 716
Ор хоног	8 428	9 340	9 572	8 871	4 888
Эмчийн тоо	68	75	78	76	84
Сувилагчийн тоо	95	98	105	108	100
Орны тоо	177	227	227	227	227

Амбулаторийн үзлэгийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 3883 (13.6%) , Ор хоног 3983 (44.9%) буурсан байна. Урьдчилан сэргийлэх тарилга 2 (0.2%) өссөн байна.

Зураг 3. Эмнэлгийн үзлэгийн үзүүлэлт



Эх үүсвэр: Эрүүл мэндийн төв



### СОЁЛ УРЛАГ

Дүүргийн соёл, урлагийн байгууллага 2021 оны эхний 2 сард олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хоргилсонтой холбогдуулан мэдээ гараагүй болно.

Хүснэгт 13. Соёл, урлагийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Ажил үйлчилгээ	Нийт	Үүнээс:					Номын сан (уншигчид)	Музейн <sup>2</sup> үзэгчид
		Урлагийн тоглолт	Хурал цуглаан	Кино үзвэр	Уралдаан тэмцээн	Дугуйлан сургалт		
Бүгд	-	-	-	-	-	-	-	-

Эх үүсвэр : Соёл урлагийн ордон



### АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

2021 оны эхний 2 сард хот тохижилтын ажил үйлчилгээний нийт орлого 59.8 сая төгрөг болж, орлогын 40.5 хувийг орон сууц, 53.8 хувийг гэр хороолол, 5.7 хувийг аж ахуйн нэгжээс хуримтлуулсан орлого эзэлж, нийтдээ 3.4 мянган тонн хогийг зөөж, тээвэрлэсэн байна.

Хүснэгт 14. Хот тохижилтын үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2019 I-II	2020 I-II	2021 I-II	Үүнээс:		
				Орон сууцны	Гэр хороолол	ААНБ
Нийт орлого, сая төгрөг	38.1	41.7	59.8	24.2	32.2	3.4
Хог тээвэрлэлт, мянган тонн	10.4	22.0	3.4	0.8	1.4	1.2

Эх үүсвэр: Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар

Хүснэгт 15. Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Шахсан ус	мянган м <sup>3</sup>	215.2	127.7	182.4	171.3	146.5
Борлуулсан ус	мянган м <sup>3</sup>	94.4	72.2	105.6	89.9	127.5
Үүнээс: Хүн амд	мянган м <sup>3</sup>	56.0	49.6	57.1	49.9	70.5
Аж ахуйн нэгж байгууллагад	мянган м <sup>3</sup>	38.4	22.6	48.5	40.0	57.0
Татан зайлуулсан бохир	мянган м <sup>3</sup>	83.6	71.5	71.1	64.4	83.2
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	114.0	79.6	153.4	136.1	191.2
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	66.1	70.6	89.1	79.8	85.0
Халаалтын орлого	сая төгрөг	39.0	39.5	42.5	62.1	69.0

Эх үүсвэр: Чандмань Налайх ОНӨААТҮГазар

2021 оны эхний 2 сард дүүргийн хэмжээнд 127.5 мянган м<sup>3</sup> ус борлуулснаас, 70.5 мянган м<sup>3</sup> (55.3%) усыг хүн амд, 57.0 мян.м3 (44.7%) усыг аж ахуйн нэгж байгууллагад түгээсэн байна.



**ТӨСӨВ**

2021 оны эхний 2 сард татварын орлого 357.2 сая, татварын бус торгуулийн орлого 59.7 сая төгрөг, нийт 416.9 сая төгрөгийн дүүргийн төсөвт төвлөрч, төлөвлөгөө 177.3 сая төгрөгөөр (29.8%) тасалдсан байна.

Татварын орлогын 61.18 хувийг хүн амын орлогын албан татвар, 0.9 хувийг хог хаягдлын үйлчилгээний хураамж, 0.02 хувийг бууны татвар, 1.2 хувийг түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, 4.8 хувийг улсын тэмдэгтийн хураамжийн орлого, 3.7 хувийг хүү торгуулийн орлого, 12.6 хувийг Татварын бус торгуулийн орлого, 15.6 хувийг газрын орлого тус тус бүрдүүлсэн байна.

Зураг 5.Орон нутгийн татварын орлого бүрдэлт



Эх үүсвэр: Татварын хэлтэс



## ГЭМТ ХЭРЭГ


Дүүрэгт 2021 оны эхний 2 сард 42 гэмт хэрэг гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 гэмт хэргээр (22.2%) буурч, гэмт хэргийн илрүүлэлт 18.8 хувьтай байна.

Дээрх 42 гэмт хэрэгт 22 сэжигтэн яллагдагч холбогдсон бөгөөд насны ангиллаар авч үзвэл, 18-24 насны 4, 25-29 насны 5, 30-34 насны 4, 35-39 насны 3, 40-44 насны 4, 45-49 насны 1, 65-69 насны 1 хүн байна.

Хүснэгт 16. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	55	96	75	54	42
Хүн амины					
Санаатай	3	-	1	1	-
Учрал	-	7	-	-	-
Бусдыг болгоомжгүй алах	-	-	7	1	3
-Хүчин	1	1	1	-	2
Дээрэм	-	2	-	-	-
Танхай	2	-	-	-	-
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	-	5	1	-	6
Хулгай					
Иргэдийн өмчийн	10	35	11	16	3
Малын	-	4	4	3	-
Автомашин	2	1	-	-	-
Залилан	4	7	5	6	4
Бусдын бие махбодид гэмтэл учруулсан	21	25	25	21	13
Авто тээвэр	2	2	2	1	-
Бусад	10	7	18	5	11
Хэрэгсэхгүй болгож мэдээнээс хасагдсан хэрэг	-	-	-	-	2
Илрүүлээгүй гэмт хэргийн тоо	5	80	55	40	
Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь	72.2	8.0	16.7	16.7	18.8
Гэмт хэрэгт холбогдогчид, бүгд	45	14	18	14	22
Үүнээс:					
Ажилгүй	32	8	12	13	14
Албан хаагч	1	1	-	-	-
Оюутан	3	1	-	-	-
Төрийн бус байгууллагын ажилтан	-	-	1	-	-
ХХЭ болон хувийн хэвшилд ажиллагч	9	4	5	-	8
Хоригдол	-	-	-	1	-
Эрүүлжүүлэгдсэн хүн	-	-	555	873	459

Зураг 4. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороодоор



Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 18 хүн гэмтэж бэртсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 32.1 сая төгрөгийн хохиролын 15.2 сая төгрөг буюу 47.3 хувийг нөхөн төлүүлсэн байна. 2021 оны эхний 2 сард 459 (эмэгтэй 24) хүнийг эрүүлжүүлж, 41 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 11

хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулжээ.

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтэс



## ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Түүхий эдийн үнэ өмнөх оны мөн үеэс тэмээний шир 5500 төгрөгөөр (5 дахин), адууны дэл 3000 төгрөгөөр (60%), адууны шир 5000 төгрөгөөр (50,0%), тус тус өсч, үхрийн шир 5000 (33,3%), хонины ноостой нэхий 500 төгрөгөөр (75,0%), ямааны ноолууртай арьс 3000 төгрөгөөр (9,1%) тус тус


бүүрсан байна.

Хүснэгт 17. Зарим түүхий эдийн үнэ, жил бүрийн эхний II сард

Түүхий эдийн нэр	Хэмжих нэгж	2018 II	2019 II	2020 II	2021 II
		төгрөг			
Тэмээний шир	ширхэг	26 000	10 000	20 000	65 000
Адууны дэл	кг	-	10 000	5 000	8 000
Адууны сүүл	кг	-	12 000	10 000	10 000
Адууны шир	ширхэг	15 000	12 000	10 000	15 000
Үхрийн шир (дундаж үнэ)	1.8-2.3 метр хэмжээтэй ширхэг	32 500	13 000	15 000	10 000
Хонины ноостой нэхий	ширхэг	4 000	1 500	2 000	500
Ямааны ноолууртай арьс	ширхэг	25 000	43 000	33 000	30 000

Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын 7 хоногийн үнийн судалгааны дүн

Зураг 6. Нэг литр шатахууны дундаж үнэ жил бүрийн II сард



Хүснэгт 18. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020. II.13					2021. II.13				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 595	1 760	2 300	-	-	1 300	1 370	1 960	-
Петровис	2 240	1 750	1 840	2 470	-	2 100	1 400	1 450	2 190	-
Магнай трейд	2 240	-	1 840	2 470	-	2 100	-	1 450	2 190	-
Сод монгол	2 240	-	1 840	2 470	-	2 100	-	1 450	2 190	-
Шунхлай	2 240	-	1 820	2 455	-	2 100	-	1 450	2 190	-
Юнигаз	-	-	-	-	1 300	-	-	-	-	1 130
Дундаж үнэ	2 240	1 672	1 820	2 433	1 300	2 100	1 350	1 434	2 144	1 130



## АЖ ҮЙЛДВЭР

2021 оны эхний 2 сард аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 6.7 хувиар, цахилгаан эрчим хүч 11.3 хувиар, усан хангамж 34.8 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан хангамж 4.0 хувиар, цахилгаан эрчим хүч 7.3 хувиар тус тус өсч, усан хангамж 17.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 19. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, жил бүрийн II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нийт үйлдвэрлэлт					
		Биет хэмжээгээр			Үнийн дүнгээр, сая төгрөг		
		2019	2020	2021	2019	2020	2021
<b>Эрчим хүчний үйлдвэр:</b>							
Цахилгаан	сая.квт.цаг	22.6	22.2	24.7	3 296.4	3 915.2	4 202.9
Дулаан	мянган гкал	26.3	26.9	28.7	984.2	970.1	1 009.1
Усан хангамж	мянган м <sup>3</sup>	318.7	171.3	230.9	84.7	89.9	74.2
<b>Олборлох үйлдвэр:</b>							
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Нүүрс	мянган тонн	-	-	-	-	-	-
Хайрга	мянган м <sup>3</sup>	-	-	-	-	-	-
Элс	мянган м <sup>3</sup>	-	-	-	-	-	-
<b>Боловсруулах үйлдвэр:</b>							
Тоосго	мянган ширхэг	-	-	102.0	-	-	40.8
Цемент	мянган тонн	-	-	-	-	-	-
Шохой	тонн	-	-	-	-	-	-
Аюултай хог хаягдал зайлуулах	тонн	-	-	175.5	-	-	127.4
Аюулгүй хог хаягдал булах	тонн	-	-	3419	-	-	59.8
Оёдол	мянган ширхэг	13.5	0.3	-	226.9	6.3	-
Гэр ахуйн оёмол эдлэл	мянган ширхэг	0.3	0.4	-	5.1	14.8	-
Арьсан цүнх, түрийвч эдлэл	мянган ширхэг	9.8	2.2	-	40.3	19.9	-
Замаска	тонн	-	-	5.0	-	-	1.3
Барилгын шавардлагын хар замаска	тонн	-	-	3.0	-	-	0.95
Хэвлэлийн будаг	мянган ширхэг	-	4.5	1.8	-	125.2	93.2
<b>Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл:</b>							
Талх	тонн	7.32	4.8	6.7	15.2	9.7	7.4
Нарийн боов, жигнэмэг	тонн	10.8	3.1	4.57	21.0	6.0	10.4
Эмчилгээний цай	килограмм	905	-	-	29.6	-	-
Үхрийн шинэ, сэврээсэн мах	тонн	-	-	81.2	-	-	611.6
Хонины шинэ, сэврээсэн мах	тонн	-	-	98.6	-	-	657.7
Ямааны шинэ, сэврээсэн мах	тонн	-	-	7.3	-	-	42.4
Адууны шинэ, сэврээсэн мах	тонн	-	-	275.1	-	-	1 725.7
Утсан чанасан болон хагас боловсруулсан мах	тонн	85.2	250.0	1375.0	622.3	1 785.5	11 398.3
Өлөн гэдэс	мянган гогцоо	16.0	-	-	288.0	-	-
Цэвэр ус	мянган литр	901.3	316.8	-	128.7	61.5	-

Эх үүсвэр: Дүүргийн аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа тогтмол явуулсан ААН-ын дүнгээр



## МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

Телефон цэгийн тоо өмнөх оны мөн үеэс 137 (21.1%) өссөн байна. Нийт суурин телефон цэгийн 503 (64.1%) нь айл өрхийн эзэмшилд байгаа бол 190 (24.2%) нь төсвийн байгууллагад, 92 (11.7%) нь бизнесийн байгууллагуудад ашиглагдаж байна.

Хүснэгт 20. Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Нийт орлого	сая төгрөг	33.2	35.7	39.9	38.4	43.2
Үүнээс: хүн амд үзүүлсэн үйлчилгээний	сая төгрөг	16.3	17.5	19.5	18.8	21.1
Телефон цэг	тоо	532	571	617	648	785
Үүнээс: айл өрх	тоо	399	317	346	392	503
Интернет үйлчилгээний цэг	тоо	2	2	2	2	2
Интернет үйлчилгээний суудал	тоо	20	20	20	20	17
Интернет үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчид	тоо	3 440	979	588	310	210
Интернетийн байнгын хэрэглэгчид	тоо	179	195	147	79	85
Таксофон	тоо	1	1	1	1	1

Хүснэгт 21. Кабелийн телевизийн үзүүлэлт, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт/он	хэмжих нэгж	2017 I-II	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2020 I-II
КТВ-ийн орлого	мян.төг	27 680.3	31 876.3	11 912.0	11 056.7	11 318.0
Хэрэглэгч	тоо	3 575	2 430	3 575	1 258	1 258



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дүүргийн Онцгой байдлын хэлтэс 2021 оны эхний 2 сард гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж 45 аж ахуйн нэгж, байгууллагад 151 зөрчил илрүүлэн, 108 зөрчлийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 6, мэдэгдэл 25, зөрчлийн тэмдэглэл 4, дүгнэлт 4, гал түймэр унтраасан нотломж 9, танилцуулга 3, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 12 хүргүүлсэн байна. Мөн объектын гал түймрийн 9 дуудлагаар ажиллаж, 186.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Хүснэгт 22. Гал түймрийн дуудлагын тоо, жил бүрийн эхний II сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II
Бүгд			18	12	9
Өмчийн хэлбэрээр:					
Төрийн өмч	тоо	4	2	-	-
Хувийн өмч	тоо	14	8	7	9
Аж ахуйн нэгж	тоо	-	2	1	-
Гал түймэрт өртөж шатсан:					
Нас барсан	хүүхэд том хүн	- 1	- -	- -	- -
Түлэгдэж бэртсэн	хүүхэд том хүн	- -	- -	- -	- -
Өвөл зуны сууц	тоо	8	2	1	5
Гэр	тоо	2	1	1	1
Хог, хогийн суваг	тоо	4	2	3	2
Машин техник	тоо	2	1	1	1
Барилга байгууламж	тоо	-	2	2	-
Шалтгаан:					
Цахилгааны	тоо	-	-	-	2
Ил задгай асгасан үнс, нурмаас	тоо	-	-	4	2
Лаа, тамхи, шүдэнз	тоо	4	3	-	2
Пийшин зүүхны цонолт	тоо	-	-	-	-
Машин техник гэмтэл, буруу ашигласан	тоо	1	-	-	1
Архидан согтуурснаас	тоо	1	-	-	-
Бусад	Тоо	-	-	-	-
Шалтгаан тогтоогдоогүй	Тоо	12	9	4	2
Аварсан эд хөрөнгө:					
Өвөл зуны сууц	тоо	4	2	2	4
Гэр	тоо	2	-	-	-
Барилга байгууламж	тоо	-	1	-	-
Машин техник	тоо	1	1	1	1
Эд хөрөнгө	сая төгрөг	40.0	74.0	291.0	186.0

Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтэс

2021 оны эхний 2 сард дүүргийн Засаг даргын 4 удаагийн захирамжаар нийт 112 иргэн, 7 аж ахуйн нэгж байгууллагын газартай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн байна

Хүснэгт 23. Газартай холбоотой асуудал шийдвэрлэлт, эхний II сард

Зориулалт	Газрын хэмжээг өөрчлөх	Газар эзэмших эрхийг хүчингүй болгох	Газар эзэмших эрх олгох, баталгаажуулах	Газар эзэмших эрхийг шилжүүлэх	Газар өмчлөх	Хамтран өмчлөгч хасуулах	Газрын байршил, талбай өөрчлөх	Газар эзэмших эрх сэргээх, хугацаа сунгах
Иргэн, ААНБ-ын тоо	-	4	-	112	-	-	8	5

Эх үүсвэр: Газар зохион байгуулалтын алба





## ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих, тайлагнах ажлыг “Өргөдөл, гомдлын нэгдсэн программ”-аар явуулж байгаагийн зэрэгцээ “Налайх сонсож байна” 7023-2727, 1800-1200 тусгай дугаарын утас, Засгийн газрын 11-11 утас, [www.ub1200.mn](http://www.ub1200.mn) цахим хуудас, Check my service аппликейшн зэргээр иргэдийн гомдол, хүсэлт, саналыг хүлээн авч байна.

2021 оны эхний 2 дугаар сард дүүргийн Засаг Даргын Тамгын газарт нийт 135 санал, хүсэлт, өргөдөл хүлээн авсан байна.

Эдгээрээс 123 санал, хүсэлт, өргөдөлд хариу өгч, шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа 12 санал хүсэлт байна. Санал хүсэлтийн шийдвэрлэлт 91.0 хувьтай. Ирсэн өргөдөл, гомдол, саналын 123 утсаар буюу цахимаар ирсэн байна.

Эх үүсвэр: ЗДТГ-ын нэг цонхны үйлчилгээ

Танилцуулгыг татаж авах линк :

<http://www.ubstat.mn/Report>

Налайх дүүргийн Статистикийн хэлтэс facebook хуудас

Утас: 7023-3672

УБ хот, Налайх дүүрэг ЗДТГ-ын байр 2 давхар 210 тоот